



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1180

Дадал сум

**Засаг даргын нөөц сангаас зардал  
гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/154 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын цэрэг-эх оронч хүмүүжил олгон, эх орон, эх хэл, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэх зорилгоор зохион байгуулагдаж буй аймгийн аварга шалгаруулах цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнд тус сумаас оролцож буй сурагчдын бэлтгэл үйл ажиллагааны зардал гаргасугай.

2. Зардлын 880,000 (Найман зуун ная) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000245